

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар цэцэрлэг 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/84/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Дархан-Уул аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:
Утас: 70378845
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 70371889
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Э.Эрдэнэбат
Утас: 99352099
Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	20
5.2 Албан шаардлага	20
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ,ЗДНХөрөнгө	Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН УУЛ АЙМГИЙН 18 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
О.ОЮУНЧИМЭГ ТАНАА

2025.02.25 № 95

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 24,901.5 мянган төгрөгийн компьютер, 3,880.8 мянган төгрөгийн ухаалаг самбар, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 8,200.0 мянган төгрөгийн аяга таваг угаагч эцэг, эхийн хандиваар 1,258.0 мянган төгрөгийн шкаф хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 865,700.5 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 34.1 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Дархан сумын 18 дугаар цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 100 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 100 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ


2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	191,628,486.95	310,384,161.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	131,948,196.95	237,833,528.10
312	Банканд байгаа бэлэн мөнгө	131,948,196.95	237,833,528.10
3121	төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах	131,948,196.95	237,833,528.10
33	АВЛАГА	-	-
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	59,680,290.00	72,550,633.00
351	Түүхий эд материал	1,849,262.00	1,648,932.00
3511	Тусгай зориулалттай материал	-	-
3513	Эм боох материал	1,849,262.00	1,648,932.00
354	Хангамжийн материал	57,831,028.00	70,901,701.00
35410	Бичиг хэргийн материал	1,404,650.00	1,031,500.00
35420	Аж ахуйн материал	2,641,049.00	1,635,049.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,325,100.00	3,143,100.00
35440	Түлш, шатах тослох материал	-	-
3545	Барилгын засварын материал	2,861,900.00	6,043,950.00
3546	Хүнсний материал	8,490,815.00	7,639,675.00
35470	Бусад хангамжийн материал	39,107,514.00	51,408,427.00
36	НӨӨЦ БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,554,859,256.06	1,533,247,770.64
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,554,859,256.06	1,533,247,770.64
392	Биет хөрөнгө	1,109,609,349.46	1,088,147,770.64
39201	Барилга, байгууламж орон сууц	1,194,089,956.00	1,194,089,956.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(164,545,306.89)	(204,900,754.28)
39203	Авто тээврийн хэрэгсэл		
39204	Хуримтлагдсан элэгдэл		
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55,034,885.00	88,827,185.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(15,167,875.26)	(20,357,755.48)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,645,956.00	63,442,006.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,089,700.54)	(39,055,207.43)
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,133,425.00	16,133,425.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,491,989.85)	(10,031,084.17)
39217	Ном		
393	Биет бус хөрөнгө	445,249,906.60	445,100,000.00
39301	Программ хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(974,393.40)	(1,124,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	445,100,000.00	445,100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,746,487,743.01	1,843,631,931.74

ХТ05430 39012889

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,746,487,743.01	1,843,631,931.74
51	Засгийн газрын хувь оролцоо	1,746,487,743.01	1,843,631,931.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	722,511,532.00	722,511,532.00
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	(179,408,361.01)	(82,264,172.28)
51210	Өмнөх үеийн үр дүн		(179,408,361.01)
51220	Тайлант үеийн үр дүн		97,144,188.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,203,384,572.02	1,203,384,572.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,746,487,743.01	1,843,631,931.74



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,093,203,268.45	1,369,257,980.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,881,882.00	44,503,280.00
120	Нийтлэг татварын бус орлого	26,881,882.00	44,503,280.00
12004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	6,721,882.00	48,980.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	18,961,000.00	38,240,300.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	1,199,000.00	6,214,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,066,321,386.45	1,324,754,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	991,356,500.00	1,257,267,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	991,356,500.00	1,257,267,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,830,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,830,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,134,886.45	67,487,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	54,134,886.45	67,487,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	990,208,800.91	1,272,113,791.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	990,208,800.91	1,272,113,791.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	984,265,800.91	1,267,579,536.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	645,229,320.84	865,700,542.07
210101	Үндсэн цалин	469,610,108.39	582,736,214.71
210102	Нэмэгдэл	152,084,041.96	256,295,702.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	23,535,170.49	26,668,625.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,639,966.65	109,463,783.78
210201	Тэтгэврийн даатгал	57,228,680.11	74,031,169.79
210202	Тэтгэмжийн даатгал	7,084,531.14	9,592,583.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,175,328.75	4,506,200.22
210204	Ажилгүйдлийн даатгал	1,328,863.87	4,266,786.05
210205	Эрүүл мэндийн даатгал	12,822,562.78	17,067,043.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,836,886.45	50,452,745.60
210301	Гэрэл, цахилгаан	12,081,524.08	11,606,154.68
210302	Түлш, халаалт	22,692,092.65	19,692,123.00
210303	Цэвэр, бохир ус	18,063,269.72	19,154,467.92
210304	байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	4,287,090.00	4,878,697.00
210401	Бичиг хэрэг	3,020,750.00	
210402	Тээвэр, шатахуун		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		

Handwritten notes and a red stamp are present in the bottom right corner of the table area. The stamp contains the text: ХТС54318 9922898.

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,266,340.00	34,010.00
210408	Бараа материал акталсны зардал		4,844,687.00
2105	Нормативт зардал	115,339,165.90	133,810,463.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	397,905.00	155,000.00
210502	Хоол хүнс	114,941,260.90	133,655,463.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,298,000.00	8,317,850.00
210601	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	1,298,000.00	8,317,850.00
2107	Томилолт, зочны зардал		
210702	Дотоод албан томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,833,300.00	3,138,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210805	тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,833,300.00	3,138,800.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,802,071.07	91,816,655.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,603,680.00	18,281,170.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,625,800.00	13,683,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56,572,591.07	59,851,785.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,943,000.00	4,534,254.40
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,943,000.00	0.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,943,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	4,534,254.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,534,254.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	102,994,467.54	97,144,188.73
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	0.00	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	102,994,467.54	97,144,188.73




2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,066,321,386.45	1,324,803,680.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	48,980.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	48,980.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		48,980.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,066,321,386.45	1,324,754,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	991,356,500.00	1,257,267,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	991,356,500.00	1,257,267,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,830,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	20,830,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,134,886.45	67,487,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,134,886.45	67,487,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	941,171,225.94	1,218,918,348.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	941,171,225.94	1,218,918,348.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	935,228,225.94	1,214,384,094.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	645,229,320.84	865,700,542.07
210101	Үндсэн цалин	469,610,108.39	582,736,214.71
210102	Нэмэгдэл	152,084,041.96	256,295,702.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	23,535,170.49	26,668,625.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,639,966.65	109,463,783.78
210201	Тэтгэврийн даатгалын	57,228,680.11	74,031,169.79
210202	Тэтгэмжийн даатгалын	7,084,531.14	9,592,583.95
210203	ҮОМШӨ-ий даатгалын	5,175,328.75	4,506,200.22
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,328,863.87	4,266,786.05
210205	Эрүүл мэндийн даатгалын	12,822,562.78	17,067,043.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,836,886.45	50,452,745.60
210301	Гэрэл, цахилгаан	12,081,524.08	11,606,154.68
210302	Түлш, халаалт	22,692,092.65	19,692,123.00
210303	Цэвэр, бохир ус	18,063,269.72	19,154,467.92
210304	байрны түрээс		
2104	Хангамж, бараа материал	-	-
2105	Нормативт зардал	110,581,840.00	132,804,323.00
210502	Хоол хүнс	110,581,840.00	132,804,323.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил урсгал засвар	1,298,000.00	12,500,000.00


210601	Багаж техник хэрэгсэл		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	1,298,000.00	12,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоодын томилолт	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	1,828,600.00	3,745,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210805	тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,828,600.00	3,745,000.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,813,612.00	39,717,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,327,812.00	26,368,300.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	5,485,800.00	13,349,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,943,000.00	4,534,254.40
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,943,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-
213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан а/хаагчдад дэмжлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	5,943,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт , шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	4,534,254.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,534,254.40
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	125,150,160.51	105,885,331.15
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	11,839,400.00	
0	Дотоод эх үүсвэр	11,839,400.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,839,400.00	
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(11,839,400.00)	
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,637,436.44	131,948,196.95
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	131,948,196.95	237,833,528.10



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/тегерегээр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	722,511,532.00	1,203,384,572.02	(282,402,828.55)	-	1,643,493,275.47
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	722,511,532.00	1,203,384,572.02	(282,402,828.55)		1,643,493,275.47
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			102,994,467.54		102,994,467.54
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	722,511,532.00	1,203,384,572.02	(179,408,361.01)	-	1,746,487,743.01
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	722,511,532.00	1,203,384,572.02	(179,408,361.01)		1,746,487,743.01
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			97,144,188.73		97,144,188.73
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	722,511,532.00	1,203,384,572.02	(82,264,172.28)	-	1,843,631,931.74



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,461,570,600.00	1,214,384,094.45	(247,186,505.55)	83.1%
21	Урсгал зардлын дүн	1,461,570,600.00	1,214,384,094.45	(247,186,505.55)	83.1%
210	Бараа үйлчилгээний зардал	1,461,570,600.00	1,214,384,094.45	(247,186,505.55)	83.1%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,067,762,800.00	865,700,542.07	(202,062,257.93)	81.1%
210101	Үндсэн цалин	767,122,000.00	582,736,214.71	(184,385,785.29)	76.0%
210102	Нэмэгдэл	284,662,500.00	256,295,702.36	(28,366,797.64)	90.0%
210103	Унаа хоолны хөнгөлөлт			-	0.0%
210104	Урамшуулал	15,978,300.00	26,668,625.00	10,690,325.00	166.9%
210105	Гэрээт ажлын хөлс	-	-	-	0.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,120,500.00	109,463,783.78	(12,656,716.22)	89.6%
210201	Тэтгэврийн даатгал	83,044,800.00	74,031,169.79	(9,013,630.21)	89.1%
210202	Тэтгэмжийн даатгал	9,766,800.00	9,592,583.95	(174,216.05)	98.2%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,884,700.00	4,506,200.22	(378,499.78)	92.3%
210204	Ажилгүйдлийн даатгал	4,884,700.00	4,266,786.05	(617,913.95)	87.4%
210205	ЭМД-ын хураамж	19,539,500.00	17,067,043.77	(2,472,456.23)	87.3%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,855,000.00	50,452,745.60	(9,402,254.40)	84.3%
210301	Гэрэл, цахилгаан	15,554,700.00	11,606,154.68	(3,948,545.32)	74.6%
210302	Түлш, халаалт	23,300,000.00	19,692,123.00	(3,607,877.00)	84.5%
210303	Цэвэр, бохир ус	21,000,300.00	19,154,467.92	(1,845,832.08)	91.2%
210304	байрны түрээс	-	-	-	0.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-	-	0.0%
2105	Нормативт зардал	148,630,300.00	132,804,323.00	(15,825,977.00)	89.4%
210501	Эм	-	-	-	0.0%
210502	Хоол хүнс	148,630,300.00	132,804,323.00	(15,825,977.00)	89.4%
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	-	-	-	0.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,500,000.00	12,500,000.00	-	100.0%
210601	Багаж хэрэгсэл	-	-	-	0.0%
210602	Тавилга	-	-	-	0.0%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	-	-	0.0%
210604	Урсгал засвар	12,500,000.00	12,500,000.00	-	100.0%
2107	Томилолт, зочны зардал	-	-	-	0.0%
210702	Дотоод томилолт	-	-	-	0.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	4,393,200.00	3,745,000.00	(648,200.00)	85.2%
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,393,200.00	3,745,000.00	(648,200.00)	85.2%
210807	Газрын төлбөр	-	-	-	0.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,308,800.00	39,717,700.00	(6,591,100.00)	85.8%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,959,400.00	26,368,300.00	(6,591,100.00)	80.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,349,400.00	13,349,400.00	-	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	-	0.0%

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	0.0%
213101	Засгийн газрын дотоод урсгал шилжүүлэг			-	0.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	-	0.0%
213204	ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал			-	0.0%
213208	хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			-	0.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал			-	0.0%
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	0.0%
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	0.0%
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	-	-	-	0.0%
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	0.0%
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	0.0%
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	0.0%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	0.0%
	Дотоод эх үүсвэрээр	-	-	-	0.0%
	Тоног төхөөрөмж		-	-	0.0%
	Бусад хөрөнгө			-	0.0%
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,461,570,600.00	1,320,269,425.60	(141,301,174.40)	90.3%
120	Нийтлэг бус татварын орлого	-	48,980.00	48,980.00	0.0%
1200042	Туслах үйл ажиллагааны орлого		48,980.00	48,980.00	0.0%
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,257,267,700.00	1,257,267,700.00	-	100.0%
131001	Төсвөөс санхүүжих	1,257,267,700.00	1,257,267,700.00	-	100.0%
1311	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,257,267,700.00		(1,257,267,700.00)	0.0%
	Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих	131,947,900.00		(131,947,900.00)	0.0%
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	72,355,000.00	62,952,745.60	(9,402,254.40)	87.0%
132001	Орон нутгийн төсвөөс	72,355,000.00	62,952,745.60	(9,402,254.40)	87.0%
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00	-	0.0%
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00	-	0.0%
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		131,948,196.95		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		237,833,528.10		
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0%
3	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0%
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.00	27.00	-	100.0%
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0%
	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00	-	100.0%
	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.0%



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан Уул аймгийн Дархан сумын 18 дугаар цэцэрлэг нь “Хүүхэд бүрийг өв тэгш хөгжүүлж, төлөвшүүлэхэд бүрэн дэмжлэг үзүүлэхүйц сургалтын орчин бүрдүүлж, сургалтын орчин бүрдүүлж, өөрөө суралцах хөгжих чадавхитай монгол хүмүүнийг төлөвшүүлнэ.” гэсэн эрхэм зорилгын хүрээнд 12 зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Цэцэрлэгийн дүрэм журмыг шинэчлэн боловсруулж, мөрдөж ажиллах
2. Хүүхэд төвтэй сургалтыг хэрэгжүүлж, сурлагын чанарыг тогтмол дээшлүүлэх
3. Судлагдахуунаар дамжуулан хүүхдэд мэдлэг, чадвар, хандлагыг тэгш олгох
4. Суралцах суурь чадварууд, сурах арга барилыг эзэмшүүлэх
5. Үндэсний түүх өв соёлоороо бахархагч, ёс заншлаа дээдэлдэг, өв тэгш хөгжиж, төлөвших “АДТАЙ МОНГОЛ ЖААЛ” сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх
6. Хүүхэд төвтэй суралцахуйг дэмжсэн үйлийн ээлтэй орчин бүрдүүлэх
7. Эх хэлээрээ утга төгөлдөр, зөв найруулгатай ярьж бичдэг, албан хэргээ хөтөлдөг үндэсний бичигтэн хамт олон болох
8. Гадаад нөхцөл байдлаас шалтгаалахгүйгээр сургалтын үйл ажиллагаа хэвийн явагддаг орчин нөхцөлийг бүрдүүлэх /Онлайн сургалтын платформтой болох/
9. Шүүлтүүртэй ундны цэвэр усны хүртээмжтэй болох
10. Хөл бөмбөгийн талбайтай болох
11. Багш ажилтны нийгмийн баталгааг сайжруулж, үдийн хоолны асуудлыг шийдвэрлэх
12. Хамран сургалтыг 100 хувьд хүргэх Чиг үүрэг:СӨБ-ын байгууллага юм.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолоор
- “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолоор
- “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолоор
- “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 82 тоот тогтоолоор
- “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш ажилтанд мөнгөн тэтгэмж олгох” журам Монгол улсын Засгийн газрын 2024 оны 104 тоот тогтоолоор

- “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 237 тоот тогтоолоор

- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамратсан 2024 оны А/85, А/34 тоот “Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай” тушаал

- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамратсан 2024 оны 115 тоот “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх дүгнэх” тушаал

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Дархан сумын 18 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Дархан сумын 18 дугаар цэцэрлэгийн 2024 оны Дархан Уул аймгийн Дархан сумын 8 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 97,144.2 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	131,948.2	237,833.5	105,885.3
Авлага	-	-	-
Бараа материал	59,680.3	72,550.6	12,870.3
Үндсэн хөрөнгө	1,554,859.3	1,533,247.8	(21,611.5)
Нийт хөрөнгө	1,746,487.7	1,843,631.9	97,144.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,746,487.7	1,843,631.9	97,144.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,746,487.7	1,843,631.9	97,144.2

Тайлант онд төрийн сангийн харилцах данс 237,833.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 72,550.6 мянган төгрөг болж 12,870.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 176,573.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 6,214.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал хүлээн авч, үйл ажиллагаанд 165,072.4 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,533,247.8 мянган төгрөг болж 21,611.5 мянган төгрөгөөр буурсан БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 13 ширхэг 24,901.5 мянган төгрөгийн компьютер, 1 ширхэг 3,880.8 мянган төгрөгийн ухаалаг самбар, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 1 ширхэг 8,200.0 мянган төгрөгийн аяга таваг угаагч, эцэг, эхийн хандиваар 1,258.0 мянган төгрөгийн шкаф буюу нийт 38,240.3 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/313 тоот захирамжаар 7,651.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, тайлант онд 59,851.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,843,631.9 мянган төгрөг болж 97,144.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,935,000.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 81,922.0 мянган төгрөг нийт 1,159,439.9 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,257,267.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 72,355.0 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 131,947.9 мянган төгрөг буюу нийт 1,461,570.6 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 67,487.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 62,952.7 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 4,534.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, улсын төсвөөс 1,257,267.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 1,151,431.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 105,885.3 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,214,384.1 мянган төгрөг буюу 83.1 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 247,186.5 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605 эрүүл мэндийг дэмжих	3,017.3	2,218.0	(799.3)	73.5%
2	81807 хүүхдийн хоол	148,630.3	132,804.3	(15,826.0)	89.4%
3	81816 зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	5,493.1	5,489.9	(3.2)	99.9%
4	81823 боловсролын байгууллагын ажилчдын мэргэжил дээшлүүлэх	3,017.3	1,300.0	(1,717.3)	43.1%
5	81834 БСтандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх	1,212,606.3	993,495.2	(219,111.1)	81.9%
6	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	14,351.3	14,024.0	(327.3)	97.7%
7	80233-хүүхэд хамгаалал	2,100.0	2,100.0	-	100.0%
8	80111 Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	72,355.0	62,952.7	(9,402.3)	87.0%
Нийт дүн		1,461,570.6	1,214,384.1	(247,186.5)	83.1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 74 ажилтан, үйлчлэх 21 ажилтан буюу нийт 96 ажилтантайгаар ажиллаж, 210901-Бараа үйлчилгээний бусад зардалд 26,194.5 мянган төгрөгийг тус тус зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой 21,481.5 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч оролцогч ирээгүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайланд онд тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн А/05 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр үнэлгээний хороо байгуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нээлттэй нэг тендер шалгаруулалт, шууд худалдан авалтаар дөрөв буюу нийт 163,737.5 мянган төгрөгийн бараа, үйлчилгээг худалдан авах төлөвлөгөөг байршуулж, мэдээллийг цаг тухай бүрд нь тайлагнасан.

Тус 5 багц бүхий нэг нээлттэй тендер шалгаруулалтаар 4 удаагийн тендерт шалгаруулсан боловч оролцогч оролцоогүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Дархан сумын 18 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын Шилэн дансны тухай хууль, Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Э.Эрдэнэбат гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Дархан сумын 18 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2024 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн 75 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 990,208.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,902.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан Уул аймгийн Дархан сумын 18 дугаар цэцэрлэгийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 5 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээнээс 3 мэдээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Тус цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.3-т “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны системд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүллээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус цэцэрлэгийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар илэрсэн нийт 2,754.7 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 160.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,594.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөн, биелэлтийг шалгахад зөвлөмж, төлбөрийн актыг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	160.7	1	160.7	100%
Зөвлөмж	1	2,594.0	1	2,594.0	100%
Нийт дүн	2	2,754.7	2	2,754.7	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр баталсан 1,168,815.8 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 88,451.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 141,686.7 мянган төгрөг төвлөрсөн тул харилцах дансны үлдэгдэл буурч төсвийн гүйцэтгэл 83.1% хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,316.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул 2,316.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитын явцад төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.2 Албан шаардлага

Тайлант онд байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар “өөрчлөлтгүй” дүгнэлт авсан шалтгаанаар Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын А/141 дүгээр тушаалыг баримтлан сургуулийн захирлын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлж, 2,316.0 мянган төгрөгийн урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь хэсэгт заасантай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж байхгүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

Тайлангийн 4.4.1, 4.2.2 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/										
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Зөвлөмж
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус цэцэрлэгийн эрхлэгч О.Оюунчимэгийг Дархан-Уул аймгийн БГ-ын даргын А/141 тоот тушаалаар 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "өөрчлөлтгүй" гэж дүгнэгдсэнд нэг сарын цалин 1.5 дахин нэмэгдүүлэн 2,316.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	1	2,316.0			1	2,316.0						
Дүн	1	2,316.0	-	-	1	2,316.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим системд, байгууллагын батлагдсан төсөв мэдээлэлийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-			1	-
Тус сургууль нь Ахмад настны тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1	-	-	-	1	-
Дүн	2	-			2	-